

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өсвөр үе хүнс ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2024/05/НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2024 он	Баталгаат тооцоолол аудит ХХК, захирал М.Буянбулган Утас: 77153069 Цахим хаяг: buyanbulgan@batalgaattaudit.com Аудитын менежер: Г.Цогтбаатар Цахим хаяг: tsogtbaatar@batalgaattaudit.com Ахлах аудитор: Н.Цэнгэнбаяр Цахим хаяг: tsengenbayar.n@batalgaattaudit.com
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ӨСВӨР ҮЕ ХҮНС ОНӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ Г.МӨНХЗУЛ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

᠒᠐24. 03.15 № ᠖87

танай _____-ны № _____-т

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу нийслэлийн Өсвөр үе хүнс ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн орлого, үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Нийслэлийн Өсвөр үе хүнс ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд санхүүгийн тайлангийн болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар бүх явцыг санхүүгийн тайланд толилуулж, толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал тайлант хугацаанд ажиглагдаагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт, хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тайлант онд 4 зорилтын хүрээнд 30 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж 93.1 хувиар гүйцэтгэсэн гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд удирдлага болон засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	Хөрөнгө	0.00	0.00
1.1	Эргэлтийн хөрөнгө	0.00	0.00
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	53,199,651.27	66,493,139.12
1.1.2	Дансны авлага	1,880,780.00	1,741,330.00
1.1.4	Бусад авлага	2,000.00	0.00
1.1.6	Бараа материал	135,091,519.45	208,503,655.77
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	5,086,666.67	2,131,330.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	195,260,617.39	278,869,454.89
1.2.1	Үндсэн хөрөнгө	189,321,029.23	155,404,207.10
1.2.2	Биет бус хөрөнгө	36,768,120.00	36,768,120.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	226,089,149.23	192,172,327.10
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	421,349,766.62	471,041,781.99
2.1.1.1	Дансны өглөг	1,375,000.00	0.00
2.1.1.3	Татварын өр	32,298,053.67	150,599,714.77
2.1.1.4	НДШ - ийн өглөг	39,900.00	0.00
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	2,684,035.00	0.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	36,396,988.67	150,599,714.77
2.2	Өр төлбөрийн нийт дүн	36,396,988.67	150,599,714.77
2.3	Эздийн өмч	155,762,196.93	155,762,196.93
2.3.1	төрийн	155,762,196.93	155,762,196.93
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	21,679,471.32	21,679,471.32
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	36,768,120.00	36,768,120.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	170,742,989.70	106,232,278.97
2.3.11	Эздийн өмчийн дүн	384,952,777.95	320,442,067.22
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	421,349,766.62	471,041,781.99

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	Борлуулалтын орлого (цэвэр)	7,700,404,343.81	9,718,611,366.82
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	6,843,444,674.01	8,877,038,266.48
3	Нийт ашиг (алдагдал)	856,959,669.80	841,573,100.34
5	Хүүний орлого	0.00	429,977.29
7	Эрхийн шимтгэлийн орлого	1,621,190.94	0.00
8	Бусад орлого	0.00	26,333,494.32
10	Ерөнхий ба удирдлагын зардал	582,168,844.12	838,022,451.03
12	Бусад зардал	25,351,565.59	24,767,639.56
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	251,060,451.03	5,546,481.36
19	Орлогын татварын зардал	27,641,201.66	3,031,412.09
20	Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	223,419,249.37	2,515,069.27
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	223,419,249.37	2,515,069.27
24	Нийт дэлгэрэнгүй орлогын дүн	223,419,249.37	2,515,069.27

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Өсвөр үе хүнс ОНӨААТҮГ-ын 2023 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

/төгрөгөөр/

	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	155,762,196.93	21,679,471.32	36,768,120.	-52,676,259.67	161,533,528.58
3	Залруулсан үлдэгдэл	155,762,196.93	21,679,471.32	36,768,120.	-52,676,259.67	161,533,528.58
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.	0.	0.	223,419,249.37	223,419,249.37
9	2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	155,762,196.93	21,679,471.32	36,768,120.	170,742,989.7	384,952,777.95
11	Залруулсан үлдэгдэл	155,762,196.93	21,679,471.32	36,768,120.	170,742,989.7	384,952,777.95
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.	0.	0.	2,515,069.27	2,515,069.27
15	Зарласан ногдол ашиг	0.	0.	0.	-67,025,780.	-67,025,780.
17	2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	155,762,196.93	21,679,471.32	36,768,120.	106,232,278.97	320,442,067.22

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
2	Мөнгөн орлогын дүн	8,521,754,213.07	10,734,543,528.32
3	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	8,468,563,998.80	10,687,927,919.00
8	Бусад мөнгөн орлого	53,190,214.27	46,615,609.32
9	Мөнгөн зарлагын дүн (-)	8,374,756,207.27	10,656,892,815.76
10	Ажиллагчдад төлсөн	300,782,150.61	497,894,476.15
11	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	91,530,086.17	130,538,287.71
12	Бараа материал худалдан авахад төлсөн	7,168,076,532.00	9,265,974,340.00
13	Ашиглалтын зардал төлсөн	24,807,936.78	61,720,028.00
14	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	25,981,479.23	38,327,987.50
16	Татварын байгууллагад төлсөн	658,098,979.51	593,839,758.97
17	Даатгалын төлбөрт төлсөн	465,210.00	0.00
18	Бусад мөнгөн зарлага	105,013,832.97	68,597,937.43
19	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	146,998,005.80	77,650,712.56
21	Мөнгөн орлогын дүн	0.00	429,977.29
27	Хүлээн авсан хүүний орлого	0.00	429,977.29
30	Мөнгөн зарлагын дүн	70,335,700.00	4,464,000.00
31	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	70,335,700.00	4,464,000.00
37	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-70,335,700.00	-4,034,022.71
44	Мөнгөн зарлагын дүн	54,303,280.00	60,323,202.00

Өсвөр үе хүнс ОНӨААТҮГ-ын 2023 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

48	Төлсөн ногдол ашиг	54,303,280.00	60,323,202.00
50	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-54,303,280.00	-60,323,202.00
52	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	22,359,025.80	13,293,487.85
53	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	30,840,625.47	53,199,651.27
54	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	53,199,651.27	66,493,139.12

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	2023 он			
	Зорилт жилээр	Гүйцэтгэл	(Хэтэрсэн) хэмнэсэн	Хувь
Нийт орлого	8,481,144.80	9,745,374.84	(1,264,230.04)	115%
Борлуулалтын орлого	8,479,444.80	9,718,611.37	(1,239,166.57)	115%
Бусад орлого	1,700.00	26,763.47	(25,063.47)	1574%
Нийт зардал	8,415,495.83	9,739,828.36	(1,324,332.53)	116%
ББӨ	7,527,792.00	8,877,038.27	(1,349,246.27)	118%
Цалин, хоол унаа	545,359.28	552,490.20	(7,130.92)	101%
Хоол унааны зардал	51,140.00	42,126.20	9,013.80	82%
Нийгмийн даатгалын шимтгэл	74,564.41	75,112.91	(548.50)	101%
Шуудан холбоо	3,552.00	2,564.40	987.60	72%
Цахилгаан	14,022.00	15,115.27	(1,093.27)	108%
Шатахуун	26,420.50	25,196.20	1,224.30	95%
Бичиг хэрэг	3,760.00	3,906.81	(146.81)	104%
Хөдөлмөр хамгаалал	9,000.00	3,229.00	5,771.00	36%
Ашиглалтын зардал	4,152.00	4,156.94	(4.94)	100%
Хангамжийн материал	10,752.00	6,818.91	3,933.09	63%
Засварын зардал	19,000.00	14,202.99	4,797.01	75%
Түрээсийн зардал	33,600.00	35,047.96	(1,447.96)	104%
Элэгдлийн зардал	40,838.24	37,975.00	2,863.24	93%
Сэлбэг хэрэгсэл	8,750.00	4,472.49	4,277.51	51%
Сургалтын зардал	1,240.00	1,324.16	(84.16)	107%
Албан томилолт	-	-	-	0%
Бусад зардал	15,790.00	13,043.88	2,746.12	83%
Татвар, даатгал	2,724.40	1,239.13	1,485.27	45%
Үйл ажиллагааны зардал	864,664.83	838,022.45	26,642.38	97%
Үйл ажиллагааны бус зардал	23,039.00	24,767.64	(1,728.64)	108%
Татвар төлөхийн өмнөх ашиг	65,648.97	5,546.48	60,102.49	8%
Орлогын татварын зардал	6,734.90	3,031.41	3,703.49	45%
Цэвэр ашиг	58,914.07	2,515.07	56,399.00	4%
Орлогын 1 төгрөгт ногдох зардал	0.99	1.00	(0.01)	101%
Нийт авлага		1,741.00	(1,741.00)	0%
Нийт өглөг	5,000.00	150,599.70	(145,599.70)	3012%
Хөрөнгө худалдан авалт	143,400.00	4,058.20	139,341.80	3%
Орон тоо	30.00	30.00	-	100%
Дундаж цалин	1,237.00	1,246.00	(9.00)	101%

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой 5,418.2 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг санхүүгийн тайланд залруулга хийлгэн баталгаажуулж, нягтлан бодох бүртгэлтэй холбоотой зөрчлийг дахин давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бараа материалын тодруулга тайланд 5,418.2 мянган төгрөгийн зарлага дутуу илэрхийлсэн	1	5,418.2	1	5,418.2			1	5,418.2				
Дүн	1	5,418.2	1	5,418.2			1	5,418.2				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллага д шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Анхан шатны баримтуудын хөтлөлт, гүйцэтгэлд зохих журмын зааврыг мөрдлөг болгож хэвшүүлээгүй.	1	-					1	-				
Дүн	1	-					1	-				

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/, НТАГ-2024/05/НА-СТА-ОНА

**Өсвөр үе хүнс ОНӨААТҮГ-ын 2023 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим хуудсанд 2 мэдээллийг хугацаа хоцроосон, 6 мэдээллийг мэдээлээгүй.	1	-					1	-
Дүн	1	-					1	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Бараа ажил үйлчилгээний худалдан авалтад хууль, журмыг мөрдлөг болгоогүй.	1	2,779,112.0					1	2,779,112.0
Дүн	1	2,779,112.0					1	2,779,112.0
Нийт дүн	2	2,779,112.0					2	2,779,112.0

5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	6	7	8	9
1	ТБОНӨҮГ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			